

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санаа болон Иргэний хуулийн 26 дугаар зүйлийн 26.7-д “Ашгийн төлөө хуулийн этгээд нь хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлаагүй аливаа үйл ажиллагаа эрхлэх эрхтэй” гэж, мөн зүйлийн 26.8-д “Хуулийн этгээд хуульд заасан зарим үйл ажиллалгааг эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ. Үйл ажиллагааг эрхлэх эрх тусгай зөвшөөрөл авсан өдрөөс үүснэ” гэж, 189 дүгээр зүйлийн 189.2-т “Нийгэм, хувь хүний ашиг сонирхолыг хамгаалах зорилгоор зарим төрлийн гэрээг гагцхүү төрийн эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр байгуулж болно. Тусгай зөвшөөрөл олгох журмыг хуулиар тогтооно” гэж, мөн зүйлийн 189.3-т “Тусгай зөвшөөрлийн үндсэн дээр байгуулсан гэрээ нь эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрлийг авснаар хүчин төгөлдөр болно” гэж заасныг удирдлага болгон Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт “Төрийн байгууллагаас авдаг тодорхойлолт, зөвшөөрөл, лавлагаа, дүгнэлтийг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, хөдөлгөөнт холбооны технологийг ашиглан төрийн үйлчилгээний нэгдсэн порталаас үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлнэ” гэж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Зах зээл дэх төрийн оролцоог бууруулж, бизнес хөрөнгө оруулалтын орчныг сайжруулан, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлж, олон тулгуурт, хүртээмжтэй, экспортын баримжаатай эдийн засгийг бэхжүүлнэ” гэж, мөн “Төрийн байгууллагуудаас зөвшөөрөл олгох үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, зөвшөөрлийн нэгдсэн платформыг эхлүүлнэ” гэж, мөн “Төлөвлөлт, хэрэгжилт, хяналт, зөвшөөрлийн тогтолцоог шинэчилж, бүрэн цахимжуулан төрийн захиргааны үйл ажиллагааг идэвхжүүлэх ба төрийн албан хаагчдыг тогтмол чадавхжуулна” гэсэн зорилтыг дэвшүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 7 дугаар тогтоолд заасны дагуу Зөвшөөрлийн тухай хуульд заасан тусгай, энгийн зөвшөөрөл тус бүр эрсдлийн үнэлгээ хийж, эрсдлийн түвшинг тодорхойлон, түүнтэй уялдуулан эрх зүйн зохицуулалтыг оновчтой тодорхойлж, салбарын хуульд зарим харилцааг нарийвчилан зохицуулж, хууль хоорондын уялдааг хангаж, хуулийн давхардал хийдэл, зөрчлийг арилгаж, боловсронгуй болгох зорилгоор Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлж, түүнд нийцүүлж хуулийн төслийг боловсруулсан болно.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлбэрээр боловсруулж, мөн хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгыг танилцуулж байна.

Хуулийн төсөлд дараах өөрчлөлтийг тусгалаа. Үүнд:

Монгол Улсад зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагаа болон хуульд заасан зарим төрлийн үйл ажиллагааг иргэн, хуулийн этгээд төрийн байгууллагад мэдэгдэл хүргүүлэн эрхлэх зохицуулалтын талаар

Зөвшөөрөлтэйгөөр эрхлэх зохицуулалтын тухайд

Зөвшөөрлийн тухай хуулийн 1.3 дугаар зүйлийн 1-д зааснаар тусгай, энгийн зөвшөөрөлтэйгөөр эрхлэхээс бусад үйл ажиллагааг стандартад нийцүүлэн чөлөөтэй эрхлэж болох талаар хуульчилсан хэдий ч Олон улсын байгууллагуудын зөвлөмж, Монголын бизнесийн орчны судалгаагаар төрийн байгууллагуудын уялдаа холбоо, хүнд суртал, дүрэм, журмын тодорхойгүй байдлаас шалтгаалж бизнес эрхлэгчид учрах хүндрэл, бэрхшээл, эдийн засгийн дарамт буурахгүй байгаа дүн гарсаар байна.

Үндэсний аюулгүй байдал, санхүүгийн тогтвортой байдал, нийтийн ашиг сонирхол, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй болон орчиндоо аюултай зарим төрлийн үйл ажиллагааг эрхлэх, байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглахад эрх бүхий этгээдээс зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тэдгээрийн бүртгэл, хяналт, түүнчлэн зөвшөөрлийн ангилал, жагсаалтыг тогтоохтой холбоотой харилцааг зохицуулах үүднээс Зөвшөөрлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Монгол Улсын Их Хурал 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр баталсан.

Зөвшөөрлийн тухай хууль болон салбарын 160 гаруй хуулиар тусгай, энгийн зөвшөөрөл олгох харилцааг зохицуулсан байх бөгөөд хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш 15 удаагийн нэмэлт, өөрчлөлт орж, нэр томьёоны зөрчил үүсэх, зарим талаараа хуулийн уялдаа холбоо алдагдахад хүргэсэн байна.

Зөвшөөрлийн тухай хуулийн 1.3 дугаар зүйлийн 2-т Монгол Улсад зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааны жагсаалт, зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийг энэ хуулиар зохицуулна гэж заасан хэдий ч хуулиар бий болгоогүй зөвшөөрлийг бүртгэлийн нэр томьёогоор өөрчлөн хуульчилж, мөн захиргааны хэм хэмжээний актаар бүртгэлжүүлж, баталгаажуулалт нэрээр зөвшөөрөлжүүлэх практик тогтсон байна.

Уг хуулиар 13 чиглэлийн 254 тусгай зөвшөөрөл, 12 чиглэлийн 123 энгийн зөвшөөрлийг хуульчилсан байх бөгөөд салбарын хуулиар, эрх зүйн дэд актаар зөвшөөрлийг шинээр бий болгох, ерөнхий төрлийг задлах байдал түгээмэл байна.

Өөрөөр хэлбэл, Зөвшөөрлийн тухай хуульд заагаагүй зөвшөөрлийг чиглэл, төрлөөр задлан зөвшөөрөл олгох харилцаа явагдаж байгаа бөгөөд Монгол Улсын хэмжээнд 2023 оны 12 сарын байдлаар давхардсан тоогоор 20 гаруй байгууллага зөвшөөрлийг үндэслэлгүй нэмж, бүртгэл, баталгаажуулалт, гэрээ байгуулах харилцаагаар өргөжүүлэн чөлөөтэй эрхлэх боломжтой 200 гаруй үйл ажиллагааг зөвшөөрөлтэйгээр эрхлүүлж байна гэсэн судалгаа хийгдсэн байна.

Тухайлбал хууль, журмаар 265 бүртгэл, 232 дүгнэлт, 72 баталгаажуулалт, 132 гэрчилгээ, 30 магадлан итгэмжлэл, 9 сертификат нэртэй зөвшөөрлүүд байна.

Зөвшөөрлийн тухай хуулиар зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох асуудал болон бусад холбогдох харилцааг цахимжуулж, иргэн, аж ахуй нэгжид хүнд сурталгүй, шуурхай, ил тод төрийн үйлчилгээг хүргэх асуудлыг хуульчилсан. Мөн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар төрийн байгууллага хоорондын мэдээллийг солилцох, төрд байгаа мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй байх асуудлыг ч хуульчилсан.

Зөвшөөрлийн тухай хуулиар тусгай зөвшөөрлийг ажлын 22 өдрийн дотор, энгийн зөвшөөрлийг ажлын 15 өдрийн дотор олгох, мөн энгийн зөвшөөрлийг хугацаанд нь олгоогүй тохиолдолд зөвшөөрөл олгосонд тооцох зэрэг нарийвчилсан зохицуулалттай хэдий ч бизнес эрхлэж байгаа этгээд дунджаар тусгай зөвшөөрлийн хувьд 50 гаруй хоног, энгийн зөвшөөрлийг 30 гаруй хоног зарцуулж байгаа талаар, мөн зөвшөөрөл авах хүсэлт гаргахад хууль, журмаар тавигдсан нөхцөл, шаардлагын дагуу бүрдүүлж буй баримт бичгийн бүрдүүлбэрийн хувьд хамааралгүй болон давхардуулан баримт бичиг шаарддаг, шат дамжлаг ихтэй, ойлгомжгүй байдал нь аливаа үйл ажиллагааг эрхлэхэд хүндрэл учруулж байна.

Иймд хуулийн төсөлд тусгай, энгийн зөвшөөрлийн эрсдлийн түвшингөөр дахин үнэлж, үйл ажиллагааны онцлог, шинжийг тодорхойлон, бүрдүүлэх баримт бичгийн хувьд ч ялгамжтай байх нөхцлийг бүрдүүлж, Үндэсний аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхол, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, санхүүгийн тогтвортой байдалд өндөр зэргийн эрсдэлтэй үйл ажиллагаа, эсхүл үйлдвэрлэлийн зориулалтаар байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглуулахад тусгай зөвшөөрөл, Үндэсний аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхол, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, санхүүгийн тогтвортой байдалд дунд зэргийн эрсдэлтэй үйл ажиллагаа, эсхүл тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх нэмэлт үйл ажиллагаа, эсхүл тусгай болзол, шаардлагыг хангасны үндсэн дээр хэрэгжүүлэх мэргэжлийн үйл ажиллагаа, эсхүл судалгаа шинжилгээний болон ахуйн зориулалтаар байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглуулахад энгийн зөвшөөрөл олгох зохицуулалтыг тусгалаа.

Хуулийн төсөлд 183 тусгай зөвшөөрөл, 140 энгийн зөвшөөрлийг тусгасан болно.

Мэдэгдлээр эрхлэх зохицуулалтын тухайд

Зөвшөөрлийн тухай хуулийн 1.1-д “зөвшөөрөл” гэж зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдээс хуульд заасан хугацаа, нөхцөл, шаардлагын дагуу тодорхой үйл ажиллагааг эрхлүүлэх, эсхүл байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглуулахаар олгосон эрхийг” гэж заасан бол Х.Цэвэлийн тайлбар тольд “Зөвшөөрөл” гэдгийг зөвшөөрөх үйлийн нэр; зөвшөөрөлтэй хэрэг; зөвшөөрөл авсан; зөвшөөрөл олгох; нийтээрээ зөвшөөрөн хүлээсэн хэрэг” гэж, Монгол хэлний их тайлбар тольд “Тусгай зөвшөөрөл” гэдгийг үйлдвэрлэл үйлчилгээ явуулахаар татварын, хөдөлмөр эрхлэлтийн, хяналтын зэрэг байгууллагаас авах зөвшөөрөл” гэж тус тус тайлбарлажээ.

Оксфордын англи хэлний толь бичигт “**тусгай зөвшөөрөл**” (licence) гэж “эрх бүхий байгууллагаас хэн нэгэнд олгосон ямар нэгэн зүйлийг хийх, өмчлөх, эзэмших, ашиглах зөвшөөрөл” гэж тодорхойлсон бол “**зөвшөөрөл**” (permission) гэдгийг “хэн

нэгэнд ямар нэгэн зүйл хийхийг албан ёсоор зөвшөөрөх ажиллагаа, эсхүл эрх олгосон албан ёсны баримт бичиг” хэмээн тайлбарласан.

Түүнчлэн Кембрижийн толь бичигт **“тусгай зөвшөөрөл”** (license) гэдгийг *“хэн нэгэнд ямар нэгэн зүйлийг хийх болон эзэмших эрх буюу албан ёсны зөвшөөрөл олгох”* гэж тайлбарласан бол **“зөвшөөрөл”** (permission) гэдгийг *“хэн нэгэнд ямар нэгэн зүйл хийхийг зөвшөөрөх, эсхүл ямар нэгэн зүйл тохиолдохыг зөвшөөрсөн баримт бичиг”* хэмээн тус тус тайлбарлажээ.

Хэл зүйн тайлбар талаас нь үзвэл Улс орнуудын хувьд, **“тусгай зөвшөөрөл”** (license) нь тухайн үйл ажиллагааг эрхлэх мэргэжлийн үйл ажиллагааны нарийвчилсан стандарт шаардлагыг тодорхойлдог *аливаа үйл ажиллагаа явуулах, өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгосон өргөн цар хүрээтэй үйлдэл бол “зөвшөөрөл”* (permission, permit) нь ерөнхий шинжтэй, *зөвхөн аливаа зүйлийг хийх зөвшөөрөл олгох үйлдэл буюу үүнийг гэрчилсэн баримт бичиг* байна.

Дээрх нэр томъёоны тодорхойлолт, тайлбараас үзвэл **“Зөвшөөрөл”** гэдэг нь агуулгын хувьд эрх бүхий захиргааны байгууллагаас хуулиар тогтоосон эрх хэмжээний хүрээнд тодорхой төрлийн үйл ажиллагааг, тодорхой хугацаанд явуулах эрх буюу шийдвэр гаргах /өргөдөл хүлээн авах, бичиг баримтын бүрдлийг шалгах, мөн магадлан шалгах, зөвшөөрөл олгох, сунгах шийдвэр гаргах, эсхүл шийдвэр гаргахаас татгалзах, түдгэлзүүлэх, хүчингүй болсонд тооцох/, иргэн, хуулийн этгээдийн зөвшөөрөлтэйгөөр эрхлэж буй үйл ажиллагаанд нь хяналт тавих, хариуцлага тооцох зэрэг асуудлыг хамааруулсан байна.

Харин мэдэгдлийн хувьд Х.Цэвэлийн тайлбар тольд **“Мэдэгдэл”** гэдэг нь амаар буюу бичгээр өгсөн албан ёсны санамж; мэдэгдэл хийх; ...” гэж, Монгол Улсын шинжлэх ухааны академаас гаргасан Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар тольд **“Мэдэгдэл”** гэдэг нь ам болон бичгээр өгсөн албан ёсны санамж; аман зар; мэдэгдэл гаргах (хэрэг явдлын тухай албан ёсны санамж гаргах); ...” гэж тус тус тайлбарлажээ.

Гадаадын ихэнх улс үйл ажиллагааны зөвшөөрөлтэй холбоотой харилцааг нийтлэг байдлаар бие даасан хуулиар, мөн холбогдох салбарын хуулиар хамтатган зохицуулж байх бөгөөд зарим улсууд **“зөвшөөрөл, мэдэгдэл”**-ийг зохицуулалтыг нэгтгэн хуульчилсан байна.

Тухайлбал Казахстан улс /**Закон о разрешениях и уведомлениях/ Зөвшөөрөл ба мэдэгдлийн тухай хууль**¹ тус хуулиар зөвшөөрөл бол тодорхой төрлийн үйл ажиллагааны хүрээнд тодорхой үйлдэл хийх, ажиллагаа хэрэгжүүлэх эрх бөгөөд зөвшөөрөл эзэмшигч нь хуулиар тогтоосон, эсхүл тухайн зөвшөөрөлд заасан нөхцөлийг хангах үүрэгтэй байхаар зохицуулжээ.

Зөвшөөрөл ба мэдэгдлийн тухай хуулиар зөвшөөрлийг аюулын түвшингээр нь хуваасан бөгөөд аюулын түвшинг зохицуулалтын нөлөөллийн дүн шинжилгээнд үндэслэж тогтоох бөгөөд мөн 56 мэдэгдлийг хуульчилсан байна. Мэдэгдэл нь мэдэгдэл гаргагчаас холбогдох журмын дагуу өөрийн үйл ажиллагаа (үйлдэл) эхлүүлэх

¹ Закон Казахстан **“О разрешениях и уведомлениях”** от 16.05.2014 года.
https://online.zakon.kz/Document/?doc_id=31548200&pos=3;-109#pos=3;-109

(дуусгавар болгох) тухай эрх бүхий байгууллагад илгээсэн мэдээлэл гэж тодорхойлсон байна.

Мөн Эстони улсад зөвшөөрөлтэй холбоотой харилцааг Эдийн засгийн үйл ажиллагааны тухай хуулиар² зохицуулахын зэрэгцээ тухайн салбарын харилцааг зохицуулдаг хуулиар давхар зохицуулж байна.

Уг хуулиар эдийн засгийн үйл ажиллагааны эрх чөлөө нь нийтийн ашиг сонирхолд нийцсэн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлүүлэх буюу хориглох асуудлыг мөн эдийн засгийн үйл ажиллагааг **мэдэгдлээр** эрхлэх асуудлыг тус тус хуульчилжээ.

Мэдэгдэл нь иргэн, аж ахуй нэгж байгууллага холбогдох чиглэлээр эдийн засгийн үйл ажиллагаа эхлүүлэх тухай мэдэгдлийг үйл ажиллагаагаа эхлэхээс өмнө бүртгэгч байгууллагад ирүүлэх үүрэгтэй (цаашид “мэдэгдэл” гэх). Мөн мэдэгдэлд хамрагдах хэд хэдэн чиглэлээр нэгэн зэрэг үйл ажиллагаа эрхэлж эхэлсэн бол бүх үйл ажиллагааны мэдэгдэлд танилцуулах мэдээллийг ирүүлэх үүрэгтэй байхаар хуульчилсан байсан.

Дээр дурдсанчлан иргэн, аж ахуй нэгжид хүндрэлгүй, шуурхай бизнес эрхлэх боломжийг бүрдүүлэх үүднээс хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх үйлдлийн аюулгүй түвшинг харгалзан, хэрэглэгчийн эрхийг үр дүнтэй хамгаалахын тулд бизнес эрхлэгчдэд хамгийн бага ачаалал, дарамтыг бий болгох нөхцлийг бүрдүүлэх зорилготойгоор Зөвшөөрлийн тухай хуульд тодорхой төрлийн үйл ажиллагааг “мэдэгдэл”-ээр эрхлэх асуудлыг тусгалаа.

Өөрөөр хэлбэл иргэн, хуулийн этгээд Үндэсний аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхол, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, санхүүгийн тогтвортой байдалд бага зэргийн эрсдэлтэй үйл ажиллагаа, эсхүл тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх бага зэргийн эрсдэлтэй нэмэлт үйл ажиллагаа, эсхүл нэг удаагийн шинжтэй үйл ажиллагааг мэдэгдлээр эрхэлнэ.

Хуулийн төсөлд “мэдэгдэл”-ийг нэр томъёогоор тодорхойлсон бөгөөд агуулгын хувьд нь иргэн, хуулийн этгээд эрх бүхий байгууллагаас баталсан маягтын дагуу аливаа үйл ажиллагааг эхлүүлэх, дуусгавар болгох тухай мэдэгдэх, мэдэгдлийг үйл ажиллагаа эрхлэх, үйлдэл хийхээс өмнө эрх бүхий захиргааны байгууллагад хүргүүлсэн байх, мэдэгдэл хүргүүлэлгүй үйл ажиллагаа эрхлэхгүй, үйлдэл хийхгүй байх, хийсэн тохиолдолд эрүүгийн, эсхүл захиргааны хариуцлага хүлээлгэх, мөн мэдэгдэл хүлээн авах эрх бүхий байгууллагын эрх, үүрэг зэрэг асуудлыг тусгасан болно.

Хуулийн төсөлд 32 үйл ажиллагааг эрх бүхий байгууллагад мэдэгдэлээр эрхлэхээр тусгасан болно.

Зөвшөөрөл, мэдэгдлийн харилцаанд баримтлах зарчмын талаар

Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлээр Зөвшөөрөл олгох, сунгах, шинээр бий болгоход баримтлах зарчим, хэрэгжүүлэх хүрээг тодорхойлсон байх бөгөөд

² Закон об Общей части Кодекса хозяйственной деятельности. Принят 23.02.2011, вступил в силу 01.07.2014.
<https://www.riigiteataja.ee/akt/119032015051?leiaKehtiv#>

“мэдэгдэл”-ийн зохицуулалттай холбогдуулан “Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх”, “Иргэн, хуулийн этгээд, төрийн ашиг сонирхолын тэнцвэрт байдлыг хангах” зарчмыг тусгасан.

Дээрх зарчмууд нь зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагын хувьд зөвшөөрөл, мэдэгдэлтэй холбогдох аливаа бүхий л харилцаа, мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд нээлттэй, ил тод, хүртээмжтэй хүргэх үүрэгтэй, гагцхүү хуульд заасан тодорхой үндэслэлээр хязгаарлалт тогтоож болох, хуульд заасан үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлын хүрээг өргөн хүрээнд тогтоох, хуульд заасан зөвшөөрлийг олгох, сунгах, хуульд заагаагүй аливаа төрлийн үйл ажиллагааг чөлөөтэй эрхлүүлэх боломжийг олгох, мөн зөвшөөрөл хүссэн өргөдөлд хуулийн хугацаанд хариу өгөх, шийдвэр гаргах, хяналт тавих зэрэг харилцаанд баримтлах суурь зохицуулалт юм.

Зөвшөөрөл, мэдэгдлийн харилцаанд оролцогч хуулийг хэрэгжүүлэхдээ ашиг сонирхолын зөрчилгүй, хууль сонгох хэрэглэхээс ангид байх, мөн хуульд заагаагүй зөвшөөрөл, мэдэгдлийг шинээр бий болгохгүй байхад дээрх зарчмыг баримтлан оролцоно.

Зөвшөөрөл, мэдэгдлийн хугацааны талаар

Монгол Улсад зөвшөөрлийн харилцааг тодорхой хэмжээгээр зохицуулж байгаа салбарын 160 гаруй хууль, үүнээс 40 гаруй хууль нь тухайн салбарын зөвшөөрлийн харилцааг нарийвчлан зохицуулсан хуулиуд байна.

Өөрөөр хэлбэл, зөвшөөрөлд тавигдах нөхцөл, шаардлага, зөвшөөрлийг олгох, сунгах хугацаа, мөн зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүйд тооцох, дуусгавар болгох, барьцаалах, бусдад шилжүүлэх зэрэг зохицуулалтууд тухайн салбарын онцлогоос хамаарч өөр өөрөөр нарийвчлан зохицуулсан.

Зөвшөөрлийн тухай хууль нь зөвшөөрлийн нийтлэг харилцааг зохицуулж буй хууль бөгөөд бизнес эрхлэгчдэд таатай байх нөхцлийг бүрдүүлэх, үйл ажиллагаагаа тогтвортой урт хугацаанд эрхлэх боломжийг хуулиар олгох үүднээс хуулийн төсөлд тусгай зөвшөөрлийг 10 жилээс доошгүй, энгийн зөвшөөрлийг 5 жилээс доошгүй олгохоор тусгасан бол мөн мэдэгдлээр эрхлэх хугацааг 3 жилээс дээшгүй хугацаагаар үйл ажиллагааг нь эрхлүүлэх зохицуулалтыг хуулийн төслийн ... зүйлд тусгалаа.

Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасан тусгай, энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийн талаар

Зөвшөөрлийн тухай хуулиар 13 чиглэлийн 254 тусгай зөвшөөрөл, 12 чиглэлийн 123 энгийн зөвшөөрлийг хуульчилсан байх бөгөөд давхардсан тоогоор 85 төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага, төрийн зарим чиг үүргийг хуульд, эсхүл гэрээнд заасны дагуу шилжүүлэн авсан этгээд зөвшөөрөл олгохоор заасан байна.

Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 12 дахь хэсэг, 5.5 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт зөвшөөрөл шинээр хүссэн, эсхүл сунгуулах өргөдөлд хуульд заасан хугацаанд хариу өгөөгүй нь холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох үндэслэл болох талаар, мөн 5.3 дугаар зүйлийн 5-д Эрх бүхий этгээд хуульд заасан хугацаанд

энгийн зөвшөөрөл хүссэн өргөдлийн хариуг өгөөгүй бол зөвшөөрөл олгосонд тооцох талаар, 9.1 дүгээр зүйлийн 5.4-т зөвлөл нь эрх бүхий этгээдийн зөвшөөрөл олгож байгаа үйл ажиллагаанд хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, 5.5-д зөвшөөрлийн хууль тогтоомж зөрчсөн төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгуулах саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргах, 9.5 дугаар зүйлээр хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын талаар туссан хэдий ч практикт дээрх заалтууд төдийлөн хэрэгжихгүй байгаа талаар судалгаанд дурджээ.

Монгол Улсын Үндсэн Хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэж заажээ. Нийтийн эрх ашигт үйлчилдэг төрийн байгууллага, албан тушаалтан бүр үйл ажиллагаандаа энэ зарчмыг удирдлага болгож, зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээдэг байх нь ардчилсан эрх зүйт төрийн чухал шинж юм.

Гэвч төрийн эрх мэдэл хуваарилах зарчим, сонгогдсон албан тушаалтан болон төрийн өндөр албан тушаалтны эрх зүйн байдлын онцлог зэргээс хамаарч Төрийн албаны тухай хуульд заасан сахилгын хариуцлагын тогтолцоо нь төрийн жинхэнэ албан хаагчийн хувьд нарийвчилан зохицуулагдсан байна. Өөрөөр хэлбэл төрийн улс төрийн албаны тухай сахилга, хариуцлагын асуудал холбогдох хуулиудад тухайлан зохицуулагдаагүй байна.

Зөвшөөрлийн тухай хуульд зөвшөөрөл олгох субъектээр төрийн улс төрийн албан хаагч, төрийн захиргааны албан хаагч, нийтийн эрх зүйн хуулийн этгээд мөн эрх зүйн статус нь тодорхой бус зөвлөл зэрэг этгээдийг нэрлэн заасан байх бөгөөд энэ нь өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн хүрээнд тухайн этгээдэд хариуцлага тооцох боломжгүй нөхцөлд байна.

Тухайлбал, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт заасан нэн ховор амьтныг амьдаар нь гадаад улсад гаргах тусгай зөвшөөрлийг Засгийн газар олгохоор тусгажээ.

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, холбогдох бусад хуульд зааснаар Засгийн газар нь төрийн гүйцэтгэх эрх мэдлийн хамтын дээд байгууллага бөгөөд Засгийн газар нь Улсын Их Хурлын өмнө хамтын хариуцлага хүлээх хуулийн зохицуулалттай байна.

Зөвшөөрлийн тухай хууль болон холбогдох салбарын хуульд заасан эрх бүхий этгээдэд үүрэг болгосон, хориглосон асуудалд хариуцлагын асуудлыг хуулийн хүрээнд шийдвэрлэхийн тулд зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийг төрийн жинхэнэ албан хаагчаар өөрчлөн найруулж, хуулийн төсөлд тусгалаа.

Ингэснээр төрийн байгууллага, албан тушаалтан хуульд зааснаас бусад тохиолдолд зөвшөөрлийн нэр төрлийг шинээр нэмэгдүүлсэн, задалсан, салгасан түүнчлэн зөвшөөрлийг олгосон, эрх шилжүүлсэн бол хуульд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болох бөгөөд үүсэх үр дагаврыг тухайн шийдвэр гаргасан эрх бүхий этгээд, эсхүл эрх шилжүүлэн авсан этгээд хариуцана.

Зөвшөөрлийн хуульд өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагын талаар санал, дүгнэлт гаргах Зөвлөл, түүний ажлын албаны талаар

Зөвшөөрлийн тухай хуулийн 9.1 дүгээр зүйлээр Зөвшөөрлийн хуульд өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагын талаар санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий төр, хувийн хэвшил, мэргэжлийн төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн орон тооны бус зөвлөл Ерөнхий сайдын дэргэд ажиллахаар тусгасан бөгөөд Зөвлөл эрх бүхий этгээдээс олгож байгаа зөвшөөрлийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, Зөвшөөрөл шинээр нэмэх хуулийн төсөл санаачилагч Нийтийн сонсголын тухай хуульд заасан журмын дагуу хууль тогтоомжийн төслийн сонсгол явуулсан эсэхийг нягтлан шалгах, Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах асуудлаар дүгнэлт гаргаж, Засгийн газарт танилцуулах, энэ хуулийг зөрчсөн төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, захиргааны актыг хүчингүй болгуулах саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргах чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахаар хуульчилсан.

Мөн Зөвшөөрлийн тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн 2-т Зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг Засгийн газрын хэрэг эрхлэх газар гүйцэтгэхээр заасан нь ...

Зөвшөөрлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1-д зөвшөөрөл хүссэн болон сунгуулах өргөдлийг хүлээн авах, өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг магадлан шалгах, шийдвэр гаргах үйл ажиллагааны явц болон зөвшөөрөл олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон шийдвэрийн талаарх мэдээллийг агуулсан зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сантай байх бөгөөд уг сан нь цахим хэлбэртэй байна гэж, мөн зүйлийн 2-т нэгдсэн санг эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна гэж тус тус заасан байна.

Дээрх заалттай уялдуулан Зөвлөлийн хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх нөхцөл боломжоор хангах, зөвшөөрлийн аливаа харилцаанд байнгын хяналт тавих, зөвшөөрлийн тоог хязгаарлах, салбар хуулиар нэмэгдүүлэхгүй байх үүднээс Зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг эдийн засгийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гүйцэтгэх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгалаа.

Зөвшөөрлийн тухай хуулиар нийтээр зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлаагүй аливаа үйл ажиллагаа эрхлэх Иргэний хуулийн суурь зарчмыг баталгаажуулж, Монгол Улсын нутаг дэвсгэрт эрхлэхийг хориглосон үйл ажиллагаа болон зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагаа чиглэл, төрөл, тэдгээртэй холбогдох суурь харилцаа тодорхой болсон бөгөөд энэ удаагийн Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар хуулийн хэрэгжүүлэхэд тулгарч байсан асуудлууд тодорхой түвшинд шийдвэрлэгдэж, бизнес эрхлэх таатай орчин бүрдэх, төрийн хүнд суртал, баримт бичгийн давхардал, олон шат дамжлага үгүй болох, зах зээлийн харилцаанд оролцогчдын эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах, тэдгээрийг дэмжих зохицуулалт хуульд туссанаар үндэсний аюулгүй байдал, иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах цэгцтэй механизмыг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Мөн Зөвшөөрөл, мэдэгдлийн харилцааг ил тод, нээлттэй, цахим хэлбэрээр зохион байгуулахаар хуульчилсан нь иргэдэд чирэгдэл, хүнд сурталгүй төрийн

үйлчилгээг хүргэх, цаашлаад авилга, албан тушаалын гэмт хэргийн гаралт буурч, төрийн албан хаагчийн хүнд суртал багасч, олон улс дахь авлигын индексийн үзүүлэлт болон эдийн засгийн голлох үзүүлэлтүүдээрээ мэдэгдэхүйц ахиц дэвшил гарах болно.

Хуулийн төсөлд туссан асуудалтай холбогдуулан салбарын ... гаруй хуульд хууль хоорондын нийцэл, уялдааг хангах, хуулийн нэр томъёоны болон зарчмын шинжтэй өөрчлөлт тусгалаа.

---oOo---